



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/38

Мандалговь

Албан тушаалын ангилал, зэрэглэл,
цалинг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, 57.17, УИХ-ын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай” 21 дүгээр тогтоол, Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай”, Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоол “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоол “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоол “Журамд өөрчлөлт оруулах тухай” 2 дахь заалт, Аймгийн Засаг даргын, 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн “Захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох тухай” А/17 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нутгийн захиргааны хэрэгжүүлэгч агентлагийн дарга нарын албан тушаалын ангилал зэрэглэл, цалин, нэмэгдлийг хавсралтад зааснаар шинэчлэн баталсугай.
2. Шинэчлэн тогтоосон цалин, нэмэгдлийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тогтоож олгохыг холбогдох байгууллагын нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



4822111-71

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ний өдрийн 438 дугаар захирамжийн хавсралт



НУТГИЙН ЗАХИРГААНЫ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГИЙН ДАРГА НАРЫН
АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИН, НЭМЭГДЛИЙГ ШИНЭЧЛЭН
ТОГТООХ ЖАГСААЛТ

№	Хэлтэс, агентлагийн нэр	Дарга нарын нэр	Ангилал зэрэглэл	Албан тушаалын цалин	Зэрэг дэвийн нэмэгдэл	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл хувиар	Орон нутаг ажилласны нэмэгдэл хувиар
1	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга	Л.Доржбат	ТЗ-2	1211164	26%	10%	50%
2	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Н.Гантулга	ТЗ-4	1088657	32%	17%	30%
3	Эрүүл мэндийн газар	Б.Алтантөгс	ТЗ-4	1088657	-	21%	20%
4	Боловсролын газар	Ц.Уранбямба	ТЗ-4	1088657	24%	25%	20%